Монгол улсад ревматологийн өвчлөлийн бүртгэлийн өнөөгийн байдал

Д.Зулгэрэл[1], Д.Цолмон[1], Д.Нандин-Эрдэнэ[1], З.Дэвшил[1]

[1]Ревматологийн тэнхим, АУС, АШУҮИС

Үндэслэл: Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас яс булчин, холбогч эдийн өвчнийг өвчтөний хөдөлмөрийн чадвар алдагдалд хүргэдэг хоёрдахь том шалгаан болдог хэмээн тодорхойлжээ. 2012 оны байдлаар дэлхийд нийт 1.7 тэрбум хүн үений үрэвсэл болон нурууны өвдөлтөөр шаналж байна. Эдгээр өвчний тархалт нь дэлхийд жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд өнгөрсөн 20 жилд 45% ба түүнээс илүү хувиар нэмэгдээд байна[1]. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад ревматологийн тусламж үйлчилгээ өдрөөс өдөрт хөгжсөөр байгаа бөгөөд үр дүн сайтай эм бэлдмэл ч шинээр нээгдэж, эмнэлзүйн практикт нэвтэрсээр байгаа. Гэвч сүүлийн үед хэрэглэж байгаа эм бэлдмэл, эмчилгээ нь өртөгийн хувь маш үнэтэй байна.[2,3] Монгол улсад Доторын анагаахын салбарт ревматологийн шинжлэх ухаан хоцорч хөгжиж байна. Ревматологийн салбарыг хөгжүүлэхийг эрдэмтэд, практикийн эмч нар хүсэн эрмэлзэж байсан ч гэсэн тэр бүр нөхцөл нь бүрэлдэхгүй байсаар олон жил болжээ. Түүхээс харвал Монгол улсын эрүүл мэндийн статистикийн мэдээнд 1998 он хүртэл ревматологийн өвчлөлийг тусад нь бие дааж бүртгээгүй байна[2]. Ревматологийн өвчлөлийн бүртгэлийг бусад салбаруудын өвчлөлд хамааруулан бүртгэж байжээ. Тухайлбал зүрх судасны, арьсны, халдвартын, гэмтэл согогийн, мэдрэлийн өвчлөлийн бүлэгт хамааруулан бүртгэгдэж байжээ.


Зорилго: Монгол улсад ревматологийн өвчлөлийн бүртгэлийн өнөөгийн байдлыг судлах

Зорилт:

1. Монгол улсын эрүүл мэндийн статистикийн мэдээлэлд бүртгэгдсэн ревматологийн өвчлөлийг судлах
2. 1998-2018 ревматологийн өвчлөлийн хөдлөлзүйг үнэлэх

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгаа нь дискрептив, эрүүл мэндийн статистикийн мэдээлээллийг судалсан. Үр дүнг Microsoft Excel-2010 программ ашиглан тооцов.


Үр дүн: Монгол улсын эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтэнд 1998 он хүртэл ревматологийн өвчлөлийг тусад нь бие даасан байдлаар нь бүртгээгүй байжээ. Үүнээс үзвэл ревматологийн өвчлөлийг бусад өвчлөлийн бүлэгт бүртгэж байсан байна. Жишээ нь: эрхтэн тогтолцооны улаан яршил өвчнийг цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлд эсвэл арьсны өвчлөлд бүртгэж байжээ. Барьцалдаат спондиллит (ОУ-ын өвчний 10-р ангиллалаар М45) өвчнийг Бехтеревын өвчин гэдгээр нь мэдрэлийн тогтолцооны өвчлөлийн бүртгэлд оруулж байжээ.
1998-2018 оны ревматологийн өвчлөлийн байдлыг эрүүл мэндийн статистикийн мэдээнээс авч үзвэл өвчлөл жилээс жил өссөөр байна (Зураг 1).



Зураг 1.Монгол улсын ревматологийн өвчлөлийн бүртгэл (Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 1998-2018)2

Зураг 1-ээс харвал жил жилээс ревматологийн нийт өвчлөлийн бүртгэл өндөр хурдтай өсөж байна.

2018 оны эрүүл мэндийн статистикийн мэдээллээр ревматологийн нийт өвчлөлийн 143592 тохиолдол бүртгэгдсэн байна. 2018 оны байдлаар ревматологийн нийт өвчлөлийг насны бүлгээр нь авч үзвэл 25-65 насанд илүү тохиолож байна (Зураг 2).



Зураг 2. Ревматологийн өвчний насны хамаарал
(Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 оны байдлаар)


ӨГҮҮЛЭЛ

Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэлээс хүйсний ялгааг харвал эмэгтэйчүүдэд 67%, эрэгтэйчүүдэд 33% тус тус тохиолдож байв. Ревматологийн нийт өвчлөлийн тохиолдлын бүртгэлийг бүсчилсэн байдлаар нь авч үзвэл хамгийн их тохиолдол төвийн бүсд 17.1%, түүний дараагаар баруун бүсд 12.5%, удаахь нь хангайн бүсд 11.6%, зүүн бүсд хамгийн цөөн 5.4% тус тус бүртгэгдсэн байна. Харин нийслэл Улаанбаатар хотод 53.5 % ревматологийн өвчлөлийн тохиолдол бүртгэгдсэн байна (Зураг 3).




Зураг 3. Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэл: бүсчилсэн нутгаар
(Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 оны байдлаар)

Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэлийг хөдөө орон нутгийн байдлаар нь авч үзвэл Ховд аймагт, түүний дараагаар Дорноговь аймагт хамгийн их бүртгэж байгаа нь харагдлаа. Харин Говь-Алтай, Говьсүмбэр болон Сүхбаатар, Булган болон Дундговь зэрэг аймгуудад ревматологийн өвчлөлийн бүртгэл сайнгүй байна (Зураг 4).




Зураг 4. Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэл: хөдөө орон нутагт
(Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 оны байдлаар)

Бид судалгааны зорилгын хүрээнд ревматологийн нийт өвчлөлийн бүртгэлийг тав таван жилээр судалж үзлээ. 2000-2004 оны хоорондахь 5 жилийн ревматологийн өвчлөлийн тохиолдлын бүртгэлийн харахад яс үений үрэвсэл, нурууны бусад эмгэгшил давамгай бүртгэгджээ. Харин энэ онуудад булчингийн эмгэг (М60-М63), үевч ба шөрмөсний эмгэг (М65-М68), нурууны өвдөлт(М54) огт бүртгэгдээгүй байна. 2005-2009 оны хоорондахь 5 жилийн ревматологийн өвчлөлийн тохиолдлын бүртгэлд яс үений үрэвсэл, нурууны бусад эмгэгшилийн бүртгэл улам нэмэгдэж, бусад ангилалын өвчлөлийг (М65-М68) бүртгэж эхэлсэн байна. 2010-2014 оны хоорондахь 5 жилийн ревматологийн нийт өвчлөлийн тохиолдлын бүртгэлд яс үений үрэвсэл, үенйи үрэвсэл, нурууны өвчин, үений бусад үрэвсэл, нурууны бусад өвчлөлийг бүртгэл тодорхой нэмэгдсэн байлаа. 2015-2018 оны хоорондахь 4 жилийн ревматологийн өвчлөлийн тохиолдлын бүртгэлийг харахад 2010-2014 оны бүртгэлтэй ижил төстэй зураглал харагдлаа. Нийт өвчлөлийн бүргтэлийн тав таван жилийн хөдлөлзүйг үнэлвэл яс үений үрэвсэл, үений үрэвсэл, нурууны өвчин, үений бусад үрэвслийн тохиолдлын бүртгэл жилээс жилд эрчимтэй нэмэгдэж байна (Зураг 5).




Зураг 5. Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэл: 5 жилийн давтамжаар (Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2018 оны байдлаар)

Ревматологийн нийт өвчлөлийн тохиолдлын бүртгэлийг сүүлийн 10 жилийн статистик мэдээллээс авч үнэлвэл нурууны эмгэг, түүний дараагаар үений дегенератив өвчин, удаахь нь үений үрэвсэлт өвчин бусдаас их тохиолдож байлаа (Зураг 6).




Зураг 6. Ревматологийн нийт өвчлөлийн бүртгэл (Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2009-2018он)

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик мэдээллээр 2014-2018 оны хооронд хамгийн их бүртгэгдсэн холбогч эдийн аутоиммун өвчнийг үзвэл ревматоид артрит зонхилон бүртгэгдсэн байв (Зураг 7).



Зураг 7. Холбогч эдийн зохилон тохиолдох аутоиммун өвчин (Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2014-2018)

Сүүлийн үед эмнэлзүйн практикт урьд өмнө нь ховор тохиолддог байсан тулай өвчин түрэн орж ирж байгаа нь ажиглагдсан билээ. Иймд бид тулай өвчний хөдлөлзүйг тусад нь авч үзлээ. Сүүлийн 5 жилд тулай өвчний статистик бүртгэл 3.8 дахин ихэссэн байна (Зураг 8).



Зураг 8. Тулайн тохиолдлын бүртгэл (Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, 2014-2018)

Тулайн өвчлөл нь хамгийн их Улаанбаатар хотод бүртгэгдэв. Тулайн бүртгэлийг аймаг нутгаар нь авч үзвэл Дархан, Өмнөговь, Төв аймгууд эхний гурван байранд байлаа.

Хэлцэмж: Дэлхийд ревматологийн 300 гаруй өвчин бүртгэгдээд байгаа бөгөөд үүнээс хамгийн их тохиолдол бүртгэгдэж байгаа нь нурууны өвдөлт, артроз, ревматоид артрит, ясны сийрэгжилт, тулай, тогтолцооны хатуурал, тогтолцооны улаан яршил, фибромиалги зэрэг орж байна. Манай орны эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан статистик мэдээллээр ревматологийн өвчлөлөөс артроз, нурууны өвдөлт, үрэвсэлт артропати, холбогч эдийн өвчнүүд зэрэг нь давамгайлан бүртгэгджээ. Жишээ нь: АНУ-д 1000 хүн амд ревматоид артрит 0.5-1%-д, өвдөгний үенйи артроз 25-30 насныханд 0.1%, 65-74 насныханд>30%-д тохиолдож байдаг байна. Манай оронд одоогоор ревматологийн аль ч өвчний талаар тархалтын судалгаа хийгээгүй байна.4,5Яс булчин, холбогч эдийн эмгэгүүд нь эд залуу насандаа хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэг тэргүүлэх таван шалтгааны нэг болоод байна хэмээн EULAR-аас мэдээлжээ.

ӨГҮҮЛЭЛ

Бидний хийсэн судалгаанд 1998 оноос хойшхи ревматологийн өвчлөлийн бүртгэлийг тав таван жилээр хөдлөлзүйг үнэлэхэд 2000-аас 2004 онд яс үений үрэвсэл (4.8%), үений үрэвсэл (2.48%) зонхилон бүртгэгдсэн байлаа. Энэ жилүүдэд булчингийн үрэвсэл, мөгөөрсний ба ясны эмгэгийн өвчлөл огт бүртгэгдээгүй байв. 2005-2009, 2010-2014 ба 2015-2018 онуудад яс үений үрэвсэл (1.3%, 1.7% ба 1.74%), үений үрэвсэл (1.62%, 1.5% ба 1.61%) тус тус зонхилон бүртгэгджээ. Нурууны эмгэгийг ревматологийн өвчлөлийн ангилалд 2005 оноос бүртгэн эхэлж, 2009 гэхэд бүртгэл нь 1.53%, 2010-2014 онд 2.6% болон 2015-2018 онд 2.48% тус тус нэмэгдсэн байлаа. Эдгээрээс үзвэл, 2000 оноос яс үений үрэвсэл 19.0% ба үений үрэвсэл 9.8% дахин ихсэн бүртгэгдсэн байна. Нурууны эмгэгийг 2005 оноос эхлэн бүртгэснээс хойш 9.95% дахин өсөлттэй бүртгэгдэж байна. Аутоиммун холбогч эдийн тогтолцооны өвчний бүртгэлийг харвал үений болон нурууны эмгэгээс харьцангуй цөөн бүртгэж байна. 2014-өөс 2018он хүртэл холбогч эдийн тогтолцооны өвчний бүртгэлийг өвчин тус бүрээр нь үзвэл ревматоид артритын бүртгэл 1.23%, тогтолцооны хатуурал 1.6% ба тогтолцооны улаан яршил 1.26% тус тус нэмэглсэн байна. Тулай өвчний бүртгэл сүүлийн 5 жилд 3.8% ихэссэн байна.

Дүгнэлт:

1. Манай улсад ревматологийн өвчлөл жилээс жилд нэмэгдсээр байна. Монгол улсын эрүүл мэндийн бүртгэлд зонхилон тохиолдох ревматологийн өвчлөл, тухайлбал 2000 оноос 2019 он хүртэл яс үений үрэвсэл 19,0%, үений үрэвсэл 9.8% дахин тус тус ихэссэн байна.
2. Тулай өвчин сүүлийн 5 жилийн хугацаанд (2014-2018) 3.8% дахин ихэссэн байна.

Ном зүй:

1. *http://www.thelancet.com/themed/global-burden-of-disease.*
2. *Iannazzo S, Furneri G, Demma F, et al. The Burden of Rheumatic Diseases: An Analysis of an Italian Administrative Database. RheumatolTher. ;3(1):167–177. doi:10.1007/s40744-016-0034-2*
3. *Gabriel, Sherine E, and Kaleb Michaud. "Epidemiological studies in incidence, prevalence, mortality, and comorbidity of the rheumatic diseases." Arthritis research & therapy vol. 11,3 (2009): 229. doi:10.1186/ar2669*
4. *McDougall C1, Hurd K1, Barnabe C2."Systematic review of rheumatic disease epidemiology in the indigenous populations of Canada, the United States, Australia, and New Zealand." Semin Arthritis Rheum. 2017 Apr;46(5):675-686. doi: 10.1016/j.semarthrit.2016.10.010. Epub 2016 Nov 1*
5. *O.Sangha "Epidemiology of rheumatic disease" Rheumatology 2000;39(suppl.2):3-12*
6. *Barbour KE, Helmick CG, Boring M, Brady TJ, "Prevalence of doctor-diagnosed arthritis and arthritis-attributable activity limitation- united states" 2013-2015.*
7. *Nikiphorou E, Nurmohamed MT, Szekanecz Z. Editorial: Comorbidity Burden in Rheumatic Diseases. Front Med (Lausanne). 2018; 5:197. Published 2018 Jul 3. doi:10.3389/fmed.2018.00197*